

ХАРЬЯА АГЕНТЛАГ, ТӨВИЙН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН
ИЛ ТОД БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2025.10.07

Нэг. Ерөнхий мэдээлэл

Харьяа агентлаг, төвийн “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 201 дүгээр тогтоол, 2022 оны 352 дугаар тогтоолыг тус тус баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу нээлттэй мэдээллийн цахим системд мэдээлэл хариуцагч нь 5 бүлгийн 87 мэдээллийг тайлагнахаас Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах 57 мэдээлэл байна.

Хоёр. Үнэлгээний дүн

Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-д заасан аргачлалын дагуу үнэлэхэд Харьяа агентлаг, төвийн нээлттэй, мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 80.9 хувьтай байна.

	Харьяа агентлаг, төв	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын мэдээлэл	Хүний нөөц талаар мэдээлэл	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны мэдээлэл	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээлэл	Бусад мэдээлэл	Дундаж хувь
1.	ХХҮЕГ	87.2	89.2	91	86.1	0	70.7
2.	НДЕГ	100	100	100	100	100	100
3.	ХБХХЕГ	85.4	84.5	79.1	75	80	80.8
4.	ХГБХХЕГ	78.1	69.6	65.3	76.7	79.8	73.9
5.	ХАХНХССХ	87.7	87.5	87.7	83.3	90.6	87.3
6.	ХАБЭМТ	87.7	89.2	82.7	88.8	17.5	73.1
	НИЙТ	87.6	86.6	84.3	84.9	61.3	80.9

Гурав. Дүгнэлт

Нийтийн мэдээллийн ил тод байдлын 2025 оны 3 дугаар улирлын үнэлгээний дүнг 2 дугаар улирлын үнэлгээтэй харьцуулахад харьяа агентлаг, төвийн үнэлгээний дүн өссөн үзүүлэлттэй боловч мэдээллийн чанар, хүртээмж, хугацаандаа нийтлэх, холбоосын бүрэн байдал зэрэгт анхаарах шаардлагатай байна.

Зарим байгууллагын хувьд мэдээлэл дутуу, шинэчлэгдээгүй, цахим хуудасны бүтэц, хандалтын зохион байгуулалт хангалтгүй байгаа нь Шилэн индексийн үнэлгээнд сөргөөр нөлөөлөх нөхцөл үүсэж байна.

Иймд хуульд заасан үүргээ биелүүлж иргэдийн хэрэгцээ, нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний шалгуурт нийцсэн байдлаар мэдээллийг ил тод байршуулах, дотоод хяналт, зохион байгуулалтаа сайжруулах шаардлагатай байна.

Дөрөв. Зөвлөмж

- ✓ Мэдээллийг цахим хуудсанд тодорхой, хялбар хандах боломжтой хэсэгт байршуулж байх;
- ✓ Цахим хуудаст нээлттэй мэдээллийг байршуулахдаа тухайн холбогдолтой мэдээллийг байгууллага өөрсдийн чиг үүргийн дагуу үнэн зөв бэлтгэн, боловсруулж байршуулах;
- ✓ Мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангаж, мэдээллийг тогтмол тухай бүр шинэчлэх, бүрэн бүтэн байдлыг хангах, тайлагнахад анхаарч ажиллах;
- ✓ Агентлаг, харьяа байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээний салбар байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, мэдээллийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч, тогтмол хяналт тавьж, тайлан, үнэлгээний мэдээг улирал бүр яаманд ирүүлж байх;
- ✓ Бүртгэл үүсээгүй байгаа салбар байгууллагуудыг shilen.gov.mn-д системд бүртгэж, нээлттэй мэдээлэл, тайланг тогтмол байршуулахад зөвлөмж өгч хянаж байх.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ